



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/365

Есөнбулаг сум

Газар эзэмших эрхийг бусдад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Лхагваагийн Удвалын 4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууцны зориулалтаар эзэмшиж байгаа 8208002206 нэгж талбарын дугаартай 288м2 газрыг иргэн Даграгчаагийн Жанарт, Мягмарын Мөнхбаатарын 4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууцны зориулалтаар эзэмшиж байгаа 8208003934 нэгж талбарын дугаартай 144м2 газрыг иргэн Нарантуяагийн Мэндбаярт, Лхацагийн Лхагвадоржийн үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газрын зориулалтаар эзэмшиж байгаа 8208001881 нэгж талбарын дугаартай 205м2 газрыг иргэн Жаргалсайханы Цэрэннадмид нарт эрх шилжүүлж, эзэмшил газрын хэмжээ, байршлыг хавсралтаар баталж эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшсэн иргэдийн мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж, газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (А.Алтанхуяг)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны А/352, 2026 оны А/49, 2023 оны А/158 дугаар захирамжуудын холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
 06- дугаар сарын 28- ны өдрийн 11- дүгээр
 захирамжийн хавсралт №65

ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ
 ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

д/д	Хуулийн этгээдийн нэр	Иргэн, аж ауйн нэгж байгууллагын регистрийн дугаар	Газар эзэмших ашиглах эрхийн төрөл	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ (м.кв)	Нэгж талбарын хаяг	Газар эзэмшилтийн зориулалт	Газар эзэмших, ашиглуулах хугацаа
1	Даграгчаа Жанар	ИЭ83091361	Эзэмших	8208002206	288	Жинст баг	4 ба түүнээс доош давхар орон сууц (2203)	2
2	Нарантуяа Мэндбаяр	ОЮ83060274	Эзэмших	8208003934	144	Индэрт баг	4 ба түүнээс доош давхар орон сууц (2203)	5
3	Жаргалсайхан Цэрэннадмид	ДК88121321	Эзэмших	8208001881	205	Индэрт баг	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар (2302)	12